

## МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ХАРИЛЦААТ ЯРУУ НАЙРГИЙН ТУХАЙ АСУУДАЛД

Ю.Мөнх-Амгалан

Орчин цагийн монгол хэлний эх судлалын нэгэн гол хэрэглэгдэхүүн болох уран сайхны эхийн хэлбэр, бүтэц, хэв шинж, найруулга, хэрэглээний холбогдолтой зарим өвөрмөц жишээ баримт цуглуулах явцад Монголын уран зохиолд харилцаа дуу, харилцаа шүлэг хэмээн нэрлэгддэг төрөл зүйлээс гадна бас ямар нэгэн зохиолын хариу юм уу түүнд хариулал болсон шинжтэй, бүхэлд нь харилцаат зохиол гэж нэрлэмээр өвөрмөц зүйл байгаа нь ажиглагдлаа. Энэ талаар мэргэжил нэгт нөхөдтэй санал бодлоо солилцохын үүднээс энэхүү товч тэмдэглэлийг бэлтгэв.

Харилцаа дуу, харилцаа шүлгийн талаар уран зохиолын нэвтэрхий толь бичигт өгүүлэхдээ “харилцаа шүлгийн харилцаа дуунаас ялгарах гол онцлог нь тодорхой зохиогчтой, ая дан, хөгжим, дуулаачийн урлагтай хослоогүй яруу найргийн бие даасан жанр. Бичгийн яруу найраг дахь харилцаа шүлэг ая зохиогчдоор дамжин харилцаа дуу болох нь түгээмэл. Монголын хүүхдийн аман зохиолын тоглоом наадгайн үгс, дайралцаа үг, казахын айтыс зэрэг нь мөн харилцаа шүлэглэлийн өвөрмөц хэлбэрүүд бөгөөд орчин үеийн яруу найрагт ч элбэг. Жишээ нь: С.Буяннэмэх, Магсар хурц, Өлзий-Очир нарын харилцан тайлбар эрсэн шүлгүүд, Д. Пүрэвдоржийн “Сэгс цагаан богд” найраглалын зохиомж дахь тэмээчин бүсгүй, хайгуулч залуу хоёрын харилцан шүлэглэлүүд буй” (Галбаатар, 2012:461a) гэсэн байна. Тэрчлэн харилцаа зохиолын талаар урьд өмнө дагнан гарсан судалгааны зүйл ч бас байдаг (Оюун, 1960; Баярцэцэг, 2010).

Уран зохиолын судалгааны ном бүтээлээс зэрвэсхэн шүүрдэж үзвэл С.Буяннэмэхийн тэрхүү хариу тайлбар эрсэн шүлгийн талаар судлаачид янз бүрийн цаг үед харилцан зөрүүтэй тайлбар, дүгнэлт хийж байсныг судалгааны учир шалтгааны үүднээс энд зэрэгцүүлэн оруулж байна. Тухайлбал утга зохиол судлаач, шүүмжлэгч Ц.Мөнх, зохиолч Г.Дуйнхаржав нар “С.Буяннэмэх хувьсгалт шинэ соёлыг бүтээх зам мөрийг хайж бие сэтгэлээ зориулан зүтгэж явсан тэр үеийн эрэлч сэхээтнүүдийн нэг байжээ. Тийм учраас түүний бүтээлүүд олон талтай баялаг юм. Үүний зэрэгцээ түүний хийсэн оролдлого санаачилга бүхэн нь тэр болгон бүрэн зөв амжилттай болж байсангүй учир С.Буяннэмэхийн бүтээлд шүүмжлэлтэй хандах хэрэгтэй юм. Жишээлбэл: Түүний 1928 онд бичиж байсан асуулт хариултын шүлэг нь ард түмнийг хувьсгалч ёсоор соёлжуулахад ач холбогдлоо өгч чадах ашигтай оролдлого санаачилга байж чадсангүй. Харин ч утга зохиолыг хувьсгалын их хэргээс хөндийрүүлж мэдэх хортой зүйл байсан. Тийм ч учраас уг оролдлого нь цаашдын хөгжлийг олж чадахгүй хаягдсан билээ” (1968:9) гэж бичсэн байх бөгөөд Ц.Мөнх 1969 онд 1929 оны уран үгсийн чуулганыг дахин хэвлүүлэхдээ “Тэр үед Монголын шинэ уран зохиолыг үүсгэн бий болгох зам мөрийг эрэн хайж байсан тул зохиолчдын хийсэн эрэл хайгуул, оролдлогууд нь тэр бүр онох бус алдаж

осолдох тохиол цөөнгүй байсан байна. Жишээлбэл С.Буяннэмэх нарын санаачлан оролдсон “Тайлбарлахыг эрсэн шүлэг”, Д.Чимидийн “Янагийн үнсэлт” зэрэг бүтээл нь амьдралаас тасархай буюу эсвэл амьдралыг хэт хуулбарлах хандлагатай байснаараа тухайн үедээ ч цаг үеэ олсон ашигтай уран сайхны эрэл байж чадсангүй” (1969:4-5) гээд “Нөгөө талаар 1929 оны уран үгсийн чуулганыг дахин хэвлэн нийтлэх нь уран зохиолын судлалын нэн чухал ач холбогдолтой юм. Эдгээр учир шалтгааны улмаас анхны уран үгсийн чуулганыг бүрэн эхээр нь уншигч олноо хэвлэн толилуулж байна” (1969:4) гэсэн боловч дахин хэвлэгдсэн энэхүү уран үгсийн чуулганд С.Буяннэмэх, Магсар хурц, Өлзий-Очир нарын харилцан тайлбар эрсэн шүлгүүд л хараахан багтаж ороогүй байна. Гэтэл хожим Г.Дүйнхэржав “С.Буяннэмэх хувьсгалт шинэ соёлыг бүтээх зам мөрийг хайж бие сэтгэлээ зориулан зүтгэж явсан тэр үеийн эрэлч сэхээтнүүдийн нэг байжээ. С.Буяннэмэхийн зохиолуудад Энэтхэг, Хятад, Төвд зэрэг дорно дахины улсуудын уран зохиолын хэлбэр, ардын аман зохиолын нөлөө нэлээд туссан байдаг. Түүний бичсэн хариу тайлбарлахыг хүссэн шүлгийг энэ жишээнд оруулж болох бөгөөд монгол үндэсний шинэ уран зохиолыг хөгжүүлэхийн тул хайсан эрэл хайгуулын нэг байсан гэвэл зохилтой” (1996:18) хэмээн бас тэмдэглэжээ.

Энд өгүүлэн буй зүйлтэй холбогдуулан утга зохиол судлаач С.Лувсанвандан “Энэ нь байгаа зүйлийг тэр аяар нь хуулахаас ангижруулж яруу найргийн зохиолын агуулгыг гүнзгийрүүлэх, шаардлагын нэгэн хэлбэр байсан боловч яваандаа асуулт, хариултын шүлгийг бий болгож улмаар шүлэг энгийн олон түмэн ба тайлбарлах авьяастанд, зоригдох зааг гарч, утга зохиолын онолын хувьд нийгмийн шалгарсан хэсгийн явцуу эрэлт шаардлагад нийцсэн дээжис урлаг, олон түмний ерийн хэрэгцээг хангах эгэл урлаг бий гэсэн буруу үндэслэлийг зөвтгөж, яруу найргийн практикт хийсвэр санаа хөөцөлдөж хоосон цэцэрхэлд хүргэж болох осолтой чиглэл байлаа” (1968:204). “Иймээс С.Буяннэмэхийн асуулт хариултын шүлгийн туршлага, ил, далд утгатай шүлгийн үндэслэлийг хувьсгалт уран зохиолын онол, практикийн аль ч талаар зөвтгөх үндэсгүй юм” (1988:189) гэсэн бол утга зохиол судлаач Д.Цэнд “Дүр дүрслэлийг уран яруу болгохын нөгөө нэгэн хэрэглүүр нь үгсийн санг шилжүүлсэн утгаар хэрэглэх явдал юм. Үүний нэгэн жишээ нь манай шинэ үеийн яруу найрагт 1920-1930-аад оны үес гарсан, ёгтлолоор бүтсэн “асуулт-хариултын шүлэг” юм. Үүнийг “Үнэн” сонины 1929 оны 14-рт нийтэлсэн 4 шүлгийн нэгээр үлгэр болгож тайлбарын хамт авч үзсүгэй. “Хэрвээ эдгээр шүлгийн утга нь юун ба чанар нь ямар зэргийг тодорхойлон тайлбарлаж өгөх нөхөд байваас үнэхээр шүлгийн хүрээлэнд сайн нөхөр лүгээ учрах мэт хүлээсүгэй”<sup>1</sup> гээд

Нэгэн зүйл

Өмнөт огторгуйн пад харанхуй харын дунд

Нэгэн зурвас дэнгийн гэрэл салхинд бүрэлзэнэ

Гэнэт чанадаас гаслангийн дуун чанга сонсдмогц

Зүрх палхийж гарын шидмийг чангатгана<sup>2</sup>

гэж С.Буяннэмэх бичсэн юм. Үүнийг Содномдорж, Магсар, Вандан нар тайлбарлажээ. Өлзий-Очирын тайлбарыг үзвэл:

Нэгдэх зүйлд

Гадаад дотоодод дарлагдсан хятадын харанхуй ардууд

Гагцхүү тэдний хувьсгал нь салхин дахь дэн лүгэ адил

Гашуун дарлагдал дэлбэрч эрс тэмцэл хөгжүүлэхэд

Гавшгайлан хөдөлсөн хувьсгалч ардын зориг чангарна<sup>3</sup>

гэжээ” (1974:92-93) гэх мэтээр бичсэн байна.

<sup>1</sup> Буяннэмэх. Шүлэгч нар хянамуу. - “Үнэн” сонин. 19/1929/. № 14 (156). 4 дэх нүүр.

<sup>2</sup> Буяннэмэх. Шүлэгч нар хянамуу. - “Үнэн” сонин. 19/1929/. № 14 (156). 4 дэх нүүр.

<sup>3</sup> Буяннэмэх. Шүлгийн хүрээлэн. - “Үнэн” сонин. 19/1929/. № 30-31 (171-172). 4 дэх нүүр.

С.Буяннэмэх өөрийнх нь хариу тайлбар эрсэн тэрхүү дөрвөн шүлгийн хариу болох Ш.Содномдорж, Магсар, Вандан, Өлзий-Очир нарын тус тус бичсэн шүлгийн талаар “... Үүнд нөхөр Өлзий-Очирын тайлбарласан нь их төлөв бүрнээ нийлэлцсэнийг илэрхийлэх ба жич нөхөр Содномдорж нараас тайлбарласны нэгдэх, хоёрдахь нь цөм нийлэлцэнэ. Багш нарыг бэлтгэх сургуулийн сурагч нөхөр Ванданы тайлбарласны хоёр дахь зүйл нь даруй нийлэлцсэн бөгөөд бусад зүйлийг мөн тийнхүү тайлбарлахад үл болох газаргүй. Учир нь аливаа шүлгийг гагцхүү нэгэн зүйлээр тайлбарлах бус бөгөөд аль зохилдсон байдлуудыг нийлүүлж тайлбарлах болно. Хэдийгээр тийм боловч уул зохиосон хүний чухам юуг хэлсэн саналыг мэдэх нь чухал тул эрхбиш үндсэн мөнийг олох нь эрхэм буй. Жич, Магсар авгайгаас энэ дөрвөн зүйлийн шүлгийг маш их дэлгэрэнгүйгээр тайлбарлаж ирсэн бөгөөд түүнээс нэгдэх, хоёрдахь, дөрөвдэх нь нөхөр Өлзий-Очирын тайлбарласан лугаа ихэд нийлэлцэнэ. Гагцхүү гуравдахь зүйл нь уран зохиолын зүйлээр тайлбарласан нь нийлэлцэх бөгөөд дахин тайлбарласан зүйл нь улс төрийн зүйл дээр очсон боловч тийнхүү тайлбарлахад үл болох зүйлгүй бөгөөд нөхөр Ванданы тайлбарласан лугаа ойролцоо байна” (Буяннэмэх, 1929) хэмээн дүгнэн бичсэн байна.<sup>4</sup>

Хариу тайлбар эрсэн шүлэгтэй холбогдуулан дурдах учиртай өөр нэгэн зүйл болох “уран сайхны харилцаа дуу нь ард түмний амьдрал, нийгмийн зөрчил, тэмцлийг тусган зохиогдсон үйл явдал, үйлчлэн гарах тодорхой дүр бүхий бөгөөд дуулалт жүжгийн хэмжээнд дөхөж очсон бүтээлүүд юм. Өөрөөр хэлбэл, харилцаа дуу нь үг, ая, үйл хөдлөл хослуулан хэд хэдэн дүрийн хувь заяа, үйл явдлыг дүрслэн утга санаагаа илэрхийлдэг. Иймд уран сайхны харилцаа дуу нь ардын жүжгийн үндэс болсон бөгөөд нэг хүн харилцаа ролиор ганцаар дуулах, хоёр буюу түүнээс дээш хүн харилцан дуулах хоёр үндсэн хэлбэртэй” (Сампилдэндэв, 1988:33-34) байдаг ажээ.

Харилцаа шүлэгт ая хийвэл даруй харилцаа дуу болон хувирдаг тул монгол ардын харилцаа дуу, харилцаа дуулал<sup>5</sup>, харилцаа шүлэг зэргийг нэгтгэн ерөөсөө харилцаа яруу найраг гэж нэрлэж болох юм.

Монгол ардын харилцаа дууны бадгууд нь хоорондоо өөр өөр өгүүлэгчийн зүгээс илэрхийлсэн агуулгатай харилцаа үүсгэн дуучид эдгээр бадаг болон бүлэг бадгийг нэгжгээдээр нь ээлжлэн харилцаж дуулдаг. Үүнийг бас дотор нь дараах байдлаар нарийвчлан ялгаж болно. Үүнд:

а) Нэгжгээд бадгаар харилцан дуулсан дуу: “Өвгөн шувуу хоёр” гэх мэт.

б) Нэг хэсэг бадгаар харилцан дуулсан дуу: “Сумъяа ноён” (Сумъяа ноён / Жууяар хүүхэн / Ламъяа / Жууяарын зарц хүүхэн), “Ванлий” (Ванлийгийн аав / Ванлийгийн ээж / Буянхишиг даа лам / дагуул лам / Буянхишигийн хуучин хүүхэн Сэржиймаа) гэх мэт.

Орчин үеийн дууны яруу найрагт голдуу хайрын сэдэвтэй зохиолын дууг эрэгтэй, эмэгтэй дуучид нэгжгээд бадгаар нь ээлжилж, хослон дуулах туршлага нэлээн түгээмэл шинжтэй болж байна. Энэ бол өнөө цагийн зохиолын дууны өвөрмөц нэг хэв шинж, нэгэн зүйл харилцаа дуу юм. Үүний жишээ болгож “Насан туршийн хайр” (Д.Жаргалсайхан / О.Оюунбилиг), “Сэтгэлийн үг” (У.Далантай / С.Эрдэнэцэцэг), “Их хайр” (Л.Батсүрэн / Б.Сийлэгмаа), “Бодолд өнжсөн хайр” (Т.Батсайхан / Г.Эрдэнэтунгалаг), “Хайрын орчлон” (Г.Чинболор / Б.Энхмэнд), “Зүүдэлж жаргах амраг” (С.Батсүх / Ц.Оюунцэцэг) зэрэг дууг дурдахад л хангалттай билээ. Эл жишээнд мөн “Хурд” хамтлагийн дуулдаг өвөрмөц бүтэц, зохиомж бүхий “Цэргийн бодол” дууг ч оруулж болно. Дууны дөрвөн бадгийн 1, 3 нь цэрэгт, 2, 4 нь бүсгүйд холбогдож дөрвөн бадаг нь хошоодоор харилцаа дууны бүтцийг үүсгэсэн

<sup>4</sup> Буяннэмэх. Шүлгийн хүрээлэн. - “Үнэн” сонин. 19/1929/. № 30-31 (171-172). 4 дэх нүүр.

<sup>5</sup> 13-р зууны сүүл 14-р зууны эхэн үед холбогдох “Алтан ордны үйсэн дээрх бичиг” зохиолыг бид харилцаа зохиолын нэгэн дурсгал гэж үзэж байна. Энэхүү бүтээлийн талаар утга зохиол судлаач эрдэмтэд “Энэ зохиол бол 13 дугаар зууны үеийн жинхэнэ ардын уянгат дууллын нэг дурсгалт бичиг мөн болно” (Ц.Дамдинсүрэн 1957:88), “Судлагчид уг бичгийн утга санааг нягтлан үзээд бие биенээ санан мөрөөдсөн эх, үрсийн харилцан ярилцах хэлбэрээр бичигдсэн иргэний шинж чанартай дуулал гэж үзсэн юм” (Д.Цэрэнсодном 1987:183) гэх мэтээр дүгнэжээ.

бол сондгой бадаг нь нэг дахилттай, харин тэгш бадаг нь бүсгүй ба цэргийн хоёр дахилттай байгаа нь сонин бүтэц болно. Тодруулбал, энэ дуу дөрвөн үндсэн бадгаараа харилцаа үүсгэхийн хамт 2, 4 дэх бадаг нь дотроо дахилтаараа бас харилцаатай болж уг дуу бүхэлдээ бадгаараа ч, дахилтаараа ч харилцаа дууны хэв шинжийг давхар багтаасан шинжтэй байна.

Ийнхүү нэгэн шүлгийн доторх бадгууд нь нэгжгээд баатрыг төлөөлөн харилцан ярианы шинжтэй харьцаа үүсгэхээс гадна энэ харьцаа нь нэг шүлгийн хүрээнээс халин бүхэл бүтэн найраглалын хүрээнд бас давтагдсан байж болно. Үүний нэг тод жишээ бол Д.Пүрэвдоржийн “Гэргий” [Зүрхний бичлэг] (1972) найраглал бөгөөд үүнийг уул найраглалын *ацаг, гэргийн зүрхний бичлэг, нөхрийн зүрхний бичлэг, хаялага* гэсэн хэсгээс нь харж болох юм. Энэ нь нэгэн найраглалын дотор харилцаат бүтцийг үүсгэсэн шинжтэй ажээ.

Уран зохиолын нэвтэрхий толь бичигт мөн “Захидал, зохиол дахь хоёр ба хэд хэдэн баатар шууд харилцахгүйгээр санаа бодлоо дамжуулах дүрслэлийн арга юм. Мөн зохиолчоос уншигчид хандсан захидал маягаар зохиомжлох, хол суугаа баатрууд хоорондоо зориулсан харилцан дууллын аргууд нэлээд түгээмэл дэлгэрчээ. Жишээ нь: Ц.Дамдинсүрэнгийн “*Буурал ижий минь*”, Ш.Дулмаагийн “*Хүүгийн эцэгт бичсэн захидал*”, Т.Очирхүүгийн “*Хүүгийн ээжид бичсэн захидал*”<sup>6</sup>, Д.Пүрэвдоржийн “*Сэгс цагаан богд*” найраглалын ерөнхий зохиомж нь захидал хэлбэртэй” (Галбаатар, 2012:463б) гэсэн нь бидний энд өгүүлэх зүйлтэй холбоотой юм.

Яруу найрагч Ш.Дулмаа 1971 онд “Хүүгийн эцэгт бичсэн захидал”-аа хэвлүүлсний дараа энэ зохиолын агуулга, үзэл санаатай холбоотойгоор Р.Чойном “Хүүгийн ээжид бөхийж хэлэх үгс” (1972.02.20), Ж.Баасан “Хүүгийн эхэд бичсэн захидал” (1975) гэсэн хариу зохиолууд бичжээ. Иймд нэг зохиолд холбогдсон, өөрөөр хэлбэл нэг зохиолд хариу болгосон шинжтэй хоёр зохиолчийн хоёр өөр зохиол хоёр өөр цаг үед бичигдсэн байна. Эдгээр зохиолыг ялган бүлэглэж, нэгэн ерөнхий хэв шинж, нэгдсэн тогтолцоонд оруулж үзэх шаардлагатай бөгөөд иймэрхий зохиолыг логик холбоогоор нь төрөл зүйл буюу жанрынх нь талаас эхний удаа харилцаат яруу найраг гэж нэрлэвэл зүйтэй санагдана.

Янз бүрийн цаг үед өөр өөр зохиолчийн туурвисан иймэрхүү зохиолуудыг зүгээр л захидал, эсвэл захидлын хариу гэх зэргээр тус тусад нь салангид байдлаар ойлголгүйгээр харин эхэлж бичигдсэн, захидал шинжтэй зохиолыг түүний хариу маягтай, дараа нь бичигдсэн зохиолтой нь нэгэн бүхэл бүтэн цогц байдлаар, нэгэн тогтолцоонд оруулж уул зохиолуудын бүтэц, агуулга, уран сайхны онцлогийг харилцан уялдаатай авч үзэх нь судалгааны арга зүйн хувьд бодит байдалд илүүтэй нийцнэ хэмээн үзэж байна. Ингэж үзвэл Д.Пүрэвдоржийн “Сэгс Цагаан Богд” найраглалын бүтэц нь захидлын хэлбэрээр зохиомжлогдсон, өөрөөр хэлбэл, хайгуулч залуугийн хэд хэдэн захидлын хариу болгож тэмээчин бүсгүйн бичсэн захидал учраас дотоод харьцаандаа харилцаа зохиолын шинжтэй бөгөөд харин гадаад талаас нь, тухайлбал, Т.Очирхүүгийн “Улаанбаатар баяртай” найраглалтай холбож үзвэл энэ нь харилцаа зохиолын хүрээнээс халин даруй харилцаат яруу найргийн хэв шинжид багтах юм. Үүнтэй холбогдуулан зохиогчоос “Очирхүү маань нэгэнтээ миний “Сэгс Цагаан Богд” найраглалын хариуг бичвэл ямар вэ гэсэн нь надаас битүүдээ зөвшөөрөл эрсэн хэрэг тул би цааргалсангүй. Ийнхүү “Улаанбаатар минь баяртай” найраглал гарч бид уран бүтээлийн хүж барилцсан учиртай” (Пүрэвдорж, 2006:7) хэмээснийг эш татаж болох юм.

Өөр нэгэн зүйл бол хэрэв ээждээ зориулж Ц.Дамдинсүрэнгийн бичсэн “Буурал ижий минь” найраглалын хариу болгож ээж нь хүүдээ зориулсан зохиол бичигдвэл энэ хоёр зохиол мөн л хоорондоо харилцаатай болж улмаар бидний томьёолоод байгаа харилцаат яруу

<sup>6</sup> Энэ зохиолын талаар бид нэлээн эрэл сурал болж яруу найрагчийн охин Очирхүүгийн Буянаа болон зохиолч Батсүрэн нараас лавлаад тодорхой хариу олж чадсангүй. Эцэст нь яруу найрагч Ш.Дулмаа гуайтай 2018 оны 7 дугаар сарын 1-нд утсаар ярьж магадласанд тэрбээр өөрийнх нь зохиолын хариу болгож яруу найрагч Т.Очирхүү тийм зохиол бичсэн эсэхийг сайн мэдэхгүй байна гэснээр бидний энэ удаагийн эрэл түр завсарласан билээ.

найргийн төрөл зүйл гэгчид хамаарах учиртай юм. Гэтэл ээжийнхээ хариу зохиолын хариу болгож хүү нь бас зохиол бичвэл энэ нь гадаад бүтэц талаасаа биеэ даасан харилцаа зохиол болж хувирна гэж бодож байна. Үүнийг дотоод бүтцэндээ харилцаа бүхий харилцаа дуутай зүйрлэн харьцуулбал даруй ойлгомжтой болно.

Харилцаа зохиолын бүтцийг дараах байдлаар хийсвэрлэн томъёолж болох юм. Үүнд:

А - анхны зохиол

Б - анхны зохиолын хариу зохиол

В - хариу зохиолын хариу зохиол

Угтаа яг ийм бүтэц бүхий биеэ даасан, харилцаа зохиолын жишээ одоогоор бидэнд хараахан олдоогүй байна. Гэхдээ дээр товч өгүүлсэн Д.Пүрэвдоржийн “Сэгс Цагаан Богд” найраглалыг ажиглавал хайгуулч залуугийн хэд хэдэн захидлын хариу болгож тэмээчин бүсгүй захидал бичсэн гэж үзэж болно. Энэ тухай уг найраглалд бичсэн нь:

Шувуу бүхэнд үг заагаад  
Шуудан бүрийд захиа дайгаад  
Нэгдлийн даргаас ч санаа зовохгүй  
Нээрэн та намаржин чадлаа.  
Уншаад баймаар таны захидлууд  
Уулзахын заяа өгөөч гэжээ  
Уулзахын заяа өгье гэтэл  
Учралын жаргал аваач гэжээ  
Учралын жаргал авъя гэтэл  
Улаанбаатарт ирээч гэжээ.

Иймээс энэ найраглал нь А - хайгуулч залуугийн захидлууд, Б - тэмээчин бүсгүйн захидал гэсэн дотоод бүтэцтэй бөгөөд үүн дээр В буюу Т.Очирхүүгийн “Улаанбаатар баяртай” найраглалын хайгуулч залуугийн сүүлийн захидлыг нэмж нэгэн тогтолцоонд оруулж хийсвэрлэн ойлговол сая харилцаа зохиол болон хувирах боломжтой болох ажээ.

Тэгвэл харилцаат зохиолын бүтцийг мөн бүдүүвчлэн томъёолбол дараах байдалтай юм. Үүнд:

А - анхны зохиол

Б - анхны зохиолын хариу зохиол

А + Б - харилцаат зохиол (анхны зохиол ба түүний хариу зохиол).

Эндээс үзвэл, А зохиол нь дурын, санамсаргүй ямар ч зохиол байж болох мэт боловч бас ч тийм задгай шинжтэй биш ажээ. Одоогоор бидний олж бүртгээд байгаа харилцаат зохиолын жишээ баримтын хүрээнд ажиглавал харилцаат зохиолын анхны зохиол нь агуулга, хэлбэрийн хувьд дараах байдалтай байна. Үүнд:

1. Бусдаас зориуд тайлбар хүсэж хариу эрсэн: С.Буяннэмэхийн “Тайлбарлахыг эрсэн шүлэг”, Магсар авгайн “Хариу тайлбарлахыг хүсэж ирсэн шүлэг”;

2. Хэн нэгэнд шууд хандаж бичсэн: Д.Пүрэвдоржийн “Сэгс Цагаан Богд” (Тэмээчин бүсгүйн захидал), Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидал”;

3. Хэн нэгэнд тусгайлан зориулсан: Жанчивын Шагдарын “Хан уулын цэцэг арвантаа дэлгэрлээ, дүү минь”, Т.Очирхүүгийн “Сансрын нисэгчийн ээжийн дуу”, Л.Дагвадоржийн “Цэрэг эрийн гэргийдээ дуулах дуу”, Б.Доржпаламын “Цэрэг чамдаа хайртай”, С.Оюуны “Санана даа, чи намайг санана”;

4. Бусдад санаа бодлоо илэрхийлж өчсөн: Жишээлбэл: У.Булганы “Мартъя даа”, М.Билэгсайханы “Эрчүүдээ өмөөрч бичсэн шүлэг”;

5. Хэн нэгнээс ямар нэгэн далд хариу эрэлхийлсэн: Б.Нармандахын “Тэр намайг дурсдаг болов уу”

Иймэрхүү агуулга, хэлбэр бүхий А зохиолын хариу болох Б зохиол нь судалгааны хувьд мөн нэгэн адил ихээхэн сонирхолтой юм. Хариу зохиолын гарчиг нь хүртэл “...шүлэгт тайлбарласан нь”, “...бичсэн хариу”, “...найраглалын хариу болгож бичив”, “...захидлын хариу найраглал”, “...шүлгэнд хариу болгож бичих нь”, “...захидлын хариу”, “...хариу шүлэг” гэх мэтээр ямар нэгэн А зохиолын хариу болох Б зохиолын агуулга, зорилго, шинж чанарыг давхар баталж байна. Б зохиолыг А зохиолоос салангид авч үзэхийн аргагүй тул А, Б зохиолыг нэгэн бүхэл зүйлийн хоёр тал, биеэ биеэ харилцан нөхсөн бүтээл хэмээн үзэж нэгэн тогтолцоонд нэгэн зэрэг авч үзэх ёстой гэж ойлгож байна. Чухам ийм учраас А, Б зохиолыг сэдэв, агуулга, зохиомж, өгүүлэмж зэрэг олон талаас нь харилцан шүтэлцүүлж харилцаат зохиол гэж тусгайлан нэрлэх саналтай байна.

Харилцаат яруу найргийг дотор нь зохиогчийнх нь талаас а) нэг зохиогчийн, б) хоёр болон олон зохиогчийн гэж ялгаж болно. Одоогоор бидэнд олдоод байгаа нэг зохиогчийн харилцаат шүлгийн жишээнд Б.Доржпаламын “Цэрэг чамдаа хайртай”, “Цэргийн хайр”, Л.Дагвадоржийн “Цэрэг эрийн гэргийдээ дуулах дуу”, “Цэрэг эрийн гэргийн дуу”, Т.Очирхүүгийн “Сансрын нисэгчийн ээжийн дуу”, “Сансрын нисэгч, ээждээ дуулах дуу”, Б.Нармандахын “Тэр намайг дурсдаг болов уу”, “Чамайг мартаагүй” зэрэг шүлгийг оруулж байна. Эхний хос шүлэгт хөгжмийн зохиолч Н.Жанцанноров, дараагийн хос шүлэгт хөгжмийн зохиолч Ц.Батчулуун, гуравдахь хос шүлэгт хөгжмийн зохиолч Д.Баттөмөр, сүүлийн хос шүлэгт хөгжмийн зохиолч Л.Балхжав нар тус тус дагнан ая зохиосноороо судалгааны хувьд нэн онцлог төдийгүй бас нэгэн сонирхолтой баримт болж байна.

Тухайн нэгэн шүлгийн доторх бадгууд нь өвөр зуураа харилцсан байдалтай тийм харилцаа шүлэгт ая зохиож дуу болгосон байх бөгөөд үүнийг бид уламжлалын дагуу харилцаа дуу хэмээсэнтэй санал нэг байна. Энэ тухайд холбогдох монгол ардын харилцаа дуу болон харилцаа шүлгийн талаар Э.Оюун (1960), Л.Баярцэцэг (2010) нарын судалгаанаас дэлгэрүүлэн үзэж болно.

Харилцаа болон харилцаат дууны ялгааг хялбархан ажиглаж болно. Тухайлбал, Л.Болдбаатар, С.Эрдэнэцэцэг нарын дуулдаг “Хоньчин, барилгачин хоёр” нь даруй харилцаа дуу бол Б.Сарантуяагийн дуулдаг “Мартъя даа”, Т.Ариунаагийн дуулдаг “Мартахгүй” хоёр нь хоорондоо харилцаа дуу биш, харин харилцаат дуу болно.

Иймд харилцаа шүлэгт ая зохиовол харилцаа дуу, харилцаат шүлэгт ая зохиовол харилцаат дуу болно гэсэн үг юм.

Монголын уран зохиолын судалгааны бүтээл, уран сайхны эх, эх хэрэглэгдэхүүнээс бүртгэж үзвэл харилцаат яруу найргийн хэв маяг нь захидал шүлэг, зориулал шүлэг, гэрээслэл шүлэг, өчил, ямар нэгэн хүний “хэлэх үг” зэргийн хариу болох байдлаар үүсэх боломжтой юм байна.

Харилцаат зохиолын гарчиг нь хүртэл ямар нэгэн шүтэлцээт харьцааны эгнээ үүсгэж харилцан шүтэн барилдсан нэгдлийг илэрхийлсэн шинжтэй байна. Тухайлбал,

Сэгс Цагаан Богд - Улаанбаатар

хүүгийн эцэг - хүүгийн эх

хүүгийн эцэг - хүүгийн ээж

ах - дүү

цэрэг эр - цэрэг эрийн гэргий

цэрэг эрийн сэтгэлт бүсгүй - цэрэг эр

эрчүүд - хүүхнүүд

сансрын нисэгчийн ээж - сансрын нисэгч

санана даа - мартъя

мартъя даа - мартаггүй

дурсдаг болов уу - мартаагүй гэх мэт.

Харилцаат яруу найргийн холбогдох бүтээлүүд нь агуулга, хэмжээний хувьд өөр хоорондоо ойролцоо байдаг байна. Энэ нь ямар нэгэн тодорхой зохиолд хариу болгож байгаа болохоор эхэлж гарсан зохиолын агуулга, бүтэцтэй уялдан түүнээс хамаарсан байдлаар шалтгаалдаг байж мэдэх юм. Иймэрхүү харилцаат зохиолын хоёрдогч буюу хариу зохиолын талаар тусгайлан чиглүүлж хийсэн судалгааны ажил, ажиглалт дүгнэлт одоогоор ховор байх шиг байна. Гэхдээ үүнд холбогдуулан ганц<sup>7</sup> хоёр жишээ дурдвал, Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидал”-ын хариу болох Ж.Баасангийн “Хүүгийн эхэд бичсэн захидал”-ын талаар судлаачид “Хүүгийн эхэд бичсэн захидал” шүлэг нь амьдралын эрээн барааныг эргэцүүлсэн, хүмүүст сургамжлан захисан аястай ажээ. Үүндээ ардын аман зохиолын сургаал үг, сургамжит санааг шүлгийн агуулгад шигтгэн өгсөн нь нэг ололт юм. Гэвч энэ шүлэг шинэ санаагүй, бүтээлч эрэл нээлтгүй, зөвхөн Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидал”-ын мөр бадагт хариулсан, агуулгыг эргүүлэн шүлэглэсэн төдийдээ л “захидлын хариу” хэлбэртэй болжээ” (Баттогтох, 1982), “Уул түүвэрт буй “Хүүгийн эхэд бичсэн захидал” (Ш.Дулмаагийн “захидлын” хариу), “Хар нүдэн” найраглалыг зан төрхийн талаас нь тод ялгаруулж, зохиомжийг нь нарийвчлан, хэл найруулгыг нь ихээхэн засаж янзалбал зохиол болж болох юм” (Дулам, 1984:193) гэх мэтээр дүгнэсэн нь дээр бидний өгүүлсэн зүйлтэй ямар нэг байдлаар холбогдож байна. Ер нь С.Буяннэмэх, Магсар хурц, Цэрэн-Очир нарын хариу тайлбар эрсэн шүлгийн талаарх хожмын судлаачдын шүүмж дүгнэлтээс эхлээд энд цухас дурдсан бүхнийг тоймлон үзвэл харилцаат зохиолын хоёрдогч хариу зохиол нь утга зохиол судлаач шүүмжлэгч нараас тийм ч нааштай үнэлэлт авч байгаагүй юм шиг байна.

Одоогоор нэлээд хэдэн харилцаат шүлэг, харилцаат найраглал зэрэг төрөл зүйл бүртгэгдээд байгаа тул эдгээрийг харилцаат яруу найраг хэмээн ерөнхийлөн нэрлэж болно.

Харилцаат шүлгийн жишээнд С.Буяннэмэх, Магсар хурц, Цэрэн-Очир нарын харилцан тайлбар эрсэн шүлгүүд; Т.Очирхүүгийн “Сансрын нисэгчийн ээжийн дуу”, “Сансрын нисэгч, ээждээ дуулах дуу”; Л.Дагвадоржийн “Цэрэг эрийн гэргийдээ дуулах дуу”, “Цэрэг эрийн гэргийн дуу”; Б.Доржпаламын “Цэрэг чамдаа хайртай”, “Цэргийн хайр”<sup>8</sup>; С.Оюуны “Санана даа, чи намайг санана”, У.Булганы “Мартъя даа”, Ү.Хүрэлбаатарын “Мартахгүй”<sup>9</sup>; М.Билэгсайханы “Эрчүүдээ өмөөрч бичсэн шүлэг”, Ч.Өлзийнямын “Хүүхнүүдээ өмөөрч

<sup>7</sup> Д. Пүрэвдоржийн “Сэгс Цагаан Богд” (Тэмээчин бүсгүйн захидал)-ын хариу болох Т. Очирхүүгийн “Улаанбаатар баяртай” найраглалыг “сайн зохиолын хэлбэр агуулгад дулдуйдан” бичигдсэн талаар хэн нэгэн судлаач шүүмжлэгчийн битүүхэн чимхэж бичсэнийг оюутан ахуй цагтаа халт уншсанаа бүүр түүрхэн санах боловч тэр шүүмжийг одоо хэр харахан олж амжаагүй байна.

<sup>8</sup> “Цэргийн хайр” нэртэй энэ шүлэг “Уйдах завгүй цэргийн хугацаа” нэрээр дуу болон алдаршжээ. Энэ хоёр дуутай холбогдуулан Монгол Улсын төрийн хошой шагналт, ардын жүжигчин, хөгжмийн зохиолч Н.Жанцанноров ярихдаа “...1986 оны хавар хөгжмийн зохиолч Д.Бадарчийн хүсэлтээр Б.Доржпалам “Цэрэг чамдаа хайртай” дууны шүлгийг бичиж, би Жавзмаа гэдэг дуучны хоолойд тааруулан ая зохиосон түүхтэй. Утга бол чуулгаа л дэмжээд байгаа үйл шүү дээ. Энэ онд бүх ард түмний урлагийн наадамд Сийлэгмаа “Цэрэг чамдаа хайртай”-г, Мөнхбаяр “Чандмань эрдэнэ”-ийг дуулж олныг шуугиулсан. Энэ үед Д.Бадарч бид хэд ярьж байгаад Сийлэгмаагийн дуулсан “Цэрэг чамдаа хайртай” дууны хариу болгож Мөнхбаяраар дуулуулах санаа төрж, Б.Доржпалам “Уйдах завгүй цэргийн хугацаа” дууны шүлгийг зохиосон” гэсэн байна. (Жич: Харилцаат зохиолын эхийг олж бүртгэхэд надтай хамтран ажиллаж тусалсан Дархан-Уул аймгийн Боловсрол соёлын газрын монгол хэлний мэргэжилтэн, боловсрол судлалын магистр Д.Оюунбилэг харилцаат зохиолын зарим зохиогчтой уулзаж товч ярилцлага хийсэн билээ. Түүний хийсэн ярилцлагаас үүнийг авч оруулав).

<sup>9</sup> Энэ дууны талаар Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, хэл бичгийн ухааны доктор, яруу найрагч, сэтгүүлч Ү.Хүрэлбаатар хуучлахдаа “...У.Булганы шүлэг “Мартъя” хэмээх дууг Сараа дуулж олон нийтэд хүргэсэн шүү дээ. Түүний дараа би “Мартъя” дууны “хариу дуу” болгон зохиож Сарааг дуулаач гэсэн хүсэлт тавьсан юм. Харин Сараа би “Мартъя, мартъя” гэж дуулж дуулчихаад, одоо “Мартахгүй ээ” гээд дуулаад байх боломжгүй гэдгээ хэлсэн. Хөгжмийн зохиолч Л.Галмандах миний “Мартахгүй” дууны аяыг зохиосон юм. Удалгүй тэр Монгол Улсын гавьяат жигчин Т.Ариунаагаар дуулуулъя гэсэн санал хэлсэн нь жинхэнэ эзнээ олсон доо” гэжээ (Д.Оюунбилэгийн хийсэн ярилцлагаас авлаа).

бичсэн хариу шүлэг”<sup>10</sup>; Б.Нармандахын “Тэр намайг дурсдаг болов уу”, “Чамайг мартаагүй” зэргийг оруулж байна.

Харилцаат найраглалын тоонд Жанчивын Шагдарын “Хан уулын цэцэг арвантаа дэлгэрлээ, дүү минь”, Жамцын Шагдарын “Хан уулын цэцэг арвантаа дэлгэрчээ ах минь” (Энэ найраглалыг Жанчивын Шагдарын бичсэн “Хан уулын цэцэг арвантаа дэлгэрлээ, дүү минь” гэдэг найраглалын хариу болгож бичив); Д.Пүрэвдоржийн “Сэгс Цагаан Богд” (Тэмээчин бүсгүйн захидал), Т.Очирхүүгийн “Улаанбаатар баяртай” (Д.Пүрэвдоржийн “Сэгс Цагаан Богд” найраглалын баатар тэмээчин бүсгүйн захидлын хариу найраглал); Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидал”<sup>11</sup>, Р. Чойномын “Хүүгийн ээжид бөхийж хэлэх үгс” (Ш.Дулмаагийн шүлгэнд хариу болгож бичих нь), Ж.Баасангийн “Хүүгийн эхэд бичсэн захидал” (Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидлын” хариу) зэргийг хамааруулж байна.

Ийнхүү монголын орчин үеийн уран зохиол дахь захидал шүлэг, зориулал шүлэг, өчил шүлэг тэргүүтэн ба түүний хариу шүлгийг нэгэн тогтолцоонд оруулан нэгтгэж харилцаат шүлэг, харилцаат найраглал улмаар төрөл зүйлийнх нь хувьд өргөтгөн харилцаат яруу найраг хэмээн нэрийдэж, үүнийг илэрхий нотолсон жишээ баримт болохуйц холбогдох уран сайхны эх зохиолуудыг түүвэрлэн бэлтгэж байгаадаа дулдуйдан энэхүү товч тэмдэглэлийг урьдчилан бэлтгэв.

### Харилцаат яруу найргийн эх сурвалж

Ж.Баасан. *Амьдралд би хайртай*. Ред. М.Цэдэндорж. Уб., 1980, х.43-48.

Л.Балхжав. *Миний дуунууд...* Уб., 2015, х.154, 275.

М.Билигсайхан. *Сүүний үнэртэй хорвоо*. Уб., 2002, х.5-6.

У.Булган. *Мартъя даа*. “Ням гариг” сонин. 1995.5.7. №19 (62).

Буяннэмэх. *Шүлэгч нар хянамуу*. “Үнэн” сонин. 19 (1929) оны 4-р сарын 6. №14 (156). 4 дэх нүүр.

Буяннэмэх. *Шүлгийн хүрээлэн*. “Үнэн” сонин. 19 (1929) оны 7-р сарын 2. №30-31 (171-172). 4 дэх нүүр.

<sup>10</sup> Энэ шүлгийнхээ талаар яруу найрагч Ч.Өлзийням “...Миний нэг танил ихэнхдээ “улаан зээрд” явна. Тэгснээ М.Билигсайханы “Эрчүүдээ өмөөрч бичсэн шүлэг”-ийг сонсё гэж аяглана. Өрөөнд орж ирэх бүрдээ энэ шүлгийг захиална. Тэгэх бүрдээ халамцуу явна. Энэ үнэхээр сайхан шүлэг. Олон ч эрчүүдийг “аргалж” олон ч хүүхнүүдийг ухааруулсан шүлэг. Харин ухааны цараа жаахан ядмаг “бүлэмцүү” голдуу эрчүүдийг даврааж мэдэх шүлэг. Уучлаарай эрчүүд минь яадаг билээ. Эрчүүдээ өмөөрч бичсэн шүлэгний “улаан фен” тэр “бүлэмцүү” ахад зориулж бичсэн жаахан зөрүүд шүлэг маань цахим ертөнцөд нэлээд “нисэж” байна гэнэ. “Миний найз хүний шүлэгний хариу бичдэг жанр гаргаа юу даа” гэсэн найзын маань ёж үг энэ шүлгийн хуримын зар тараахад хүргэсэн юм. Ямартай ч шүлэг төрсөн түүх нэг иймэрхүү. Хос шүлэг минь ижилсэж, хатан ухаанаар өрх гэрээ жолоодох бүсгүйчүүд, хаан ухаанаар гэрийн нараа аргамжих эрчүүдэд маань аль алинд нь уужуу ухаан авчрах болтугай. Сайхан эрчүүдийн минь самсааг шархируулах энэ аугаа шүлгийн эзэн М.Билигсайхан ахад яндар залж шүлгээ ижилсүүлэе гэсэн юм. Мэргэн уншигч та авах гээхийн ухаанаар хандаж энэхүү шүлгийн хуримын гэрч нь болж өгнө үү” гэсэн байдаг (Д.Оюунбилэгийн хийсэн ярилцлагаас авав).

<sup>11</sup> Энэ найраглалын талаар зохиогчтой хөөрөлдсөн хэсгээс эш татвал “-Чойном агсан энэ найраглалд хариу бичсэнийг та номондоо гаргасан байсан. Олон хүн хариу бичсэн байх даа?

- Тэгэлгүй яахав, олон хүн янз янзын хариу бичсэн. Зарим нь эр хүнээ өмөөрч бичсэн, зарим нь хүүхнүүдээ өмөөрч бичсэн олон хариу хүлээж авсан. Тэгээд яахав тэр дотроос Баасангийн хариуг “Утга зохиол” сонинд нийтэлсэн байсан. Чойномын хариуг бол би сүүлд өөрөө хэвлүүлсэн. Намайг тэр үед янз бүрээр дайрч, давшилж байсан л даа. Дулмаа “Хүүгийн эцэгт бичсэн захидал”-аа Чойномоор бичүүлсэн гэж миний их дотнын найз өөрчлөлт шинэчлэлт болсон чинь намайгаа матаад янз бүрээр бичсээн. Чойном шоронд байхдаа мөнгөгүй учраас Дулмаад энэ найраглалыг бичиж өгөөд, Дулмаагаас мөнгө авсан гэсэн бил үү, юу ч билээ... Тэгэхээр би зориуд өөрийнх нь бичсэн хариуг сонинд нийтлүүлсэн юм. Үнэн юм үнэнээрээ л сайхан. Амьдрал гэдэг чинь асар өргөн цар хүрээтэй, алдаж онодог юм ихтэй, асаж, бадамлах юм ч ихтэй...” гэжээ (Д.Оюунбилэгийн хийсэн ярилцлагаас авсан болно).

- Буяннэмэх. *Шүлгийн хүрээлэнгийн үргэлжлэл*. “Үнэн” сонин. 19 (1929) оны 7-р сарын 11. №33-34 (174-175). 6 дахь нүүр.
- Сономбалжирын Буяннэмэх. *Ойрхи цагийн товч*. Монголын уран зохиолын дээжис-23. Ер. ред. Л.Түдэв. Уб., 1996, х.58, 59, 60, 61.
- Сономбалжирын Буяннэмэх-И. *Тэргүүн дэвтэр. Яруу найраг*. Эмхтгэн нягталж хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв, Ван Мандуга. Уб., 2012, х.109, 110, 111, 112.
- Сономбалжирын Буяннэмэх-И. *Дөтгөөр дэвтэр. Судлал шүүмжлэл*. Эмхтгэн нягталж хэвлэлд бэлтгэсэн Д. Цэдэв, Ван Мандуга. Уб., 2012. 58-59, 81-83, 84-85 дахь тал.
- Б.Доржпалам. *Морин зүстэй толгод*. (Бүрэн түүвэр). Ред. Д.Төрбат, Э.Хархүү. Уб., 2004, х.138.
- Ш.Дулмаа. *Мөнгөн чавхдас*. Ред. Б.Явуухулан. Уб., 1977, х.114-120.
- Монгол уран зохиолын дээжис-104. Уран үгсийн чуулган-ХIII. Уб., 2008, х.79-80.
- Монгол уран зохиолын товчоон. IV боть. Уб., 2009, х.524.
- Монголын яруу найргийн цоморлиг. (1990 оноос хойш бичигдсэн зохиол). Эмхтгэж, эрхлэн хэвлүүлсэн Ц.Буянзаяа, Х.Зандраабайдий, Л.Чулуунцэцэг. Уб., 2003, х.96-97.
- Т.Очирхүү. *Улаанбаатар баяртай*. Уб., 1996, 12 х.
- Т.Очирхүү. *Урам хайрла*. Монголын уран зохиолын дээжис-70. Ботийн ред. Д.Пүрэвдорж. Уб., 2006, х.213, 214.
- С.Оюун. *Миний ертөнц*. Ред. Ш.Дулмаа. Уб., 1991, х.10.
- С.Оюун. *Шаналал, тайтгарал*. Ред. Д.Пүрэвдорж. Уб., 1991, х.113.
- Ч.Өлзийням. *Хүүхнүүдээ өмөөрч бичсэн хариу шүлэг*. “Зууны мэдээ” сонин. Уб., 2013.5.10. № 19, 120 (4434, 4435). 16 дахь нүүр.
- Д.Пүрэвдорж. *Сэгс Цагаан Богд*. Ред. Б.Явуухулан. Уб., 1976, х.214-219.
- Сэтгэлд шингэсэн дууны шилмэл түүвэр. Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн З.Батсүх. Уб., 1991, х.73, 74, 79.
- Р.Чойном. *Мөнх зул* (Яруу найрагч Р.Чойномын Ш.Дулмаад бичсэн захидлууд). Ред. Б.Ахинбаяр. Уб., 2008, х.71-76.
- Ж.Шагдар. *Сэрүүн сайхан хангай* (Найраглалууд). Ред. Д.Мягмар. Уб., 1967, х.84-95.
- Жамцын Шагдар. *Энэ яваа нас*. Ред. Б.Явуухулан. Уб., 1971, х.99-107.

### Ном зүй

- Ардын жүжиг наадмын аман зохиол*. Эмхтгэн боловсруулж удиртгал, тайлбар бичсэн Х.Сампилдэндэв. Уб., 1988.
- Балхжав Л.** *Миний дуунууд...* Уб., 2015.
- Баттогтох Д.** *Уйгагүй эрэл чухал*. Утга зохиол урлаг сонин. 1982.10.8. № 41 (1359).
- Баярцэцэг Л.** *Монгол харилцаа шүлгийн төрөл зүйл, уран сайхны шинж чанар*. Магистрын дипломын зохиол. Уб., 2010.
- Галбаатар Д.** *Уран зохиол. Онол, түүх, шүүмж*. Уб., 2012.
- Дамдинсүрэн Ц.** *Монголын уран зохиолын тойм. Нэгдүгээр дэвтэр. XIII-XVI зууны үе*. Уб., 1957.
- Дулам С.** *Залуу яруу найрагчдын номын тухай*. Яргуй. №15. Уб., 1984, х.192-200.
- Дүйнхэржав Г.** *Чандманийн түлхүүр*. Монголын уран зохиолын дээжис-23. Сономбалжирын Буяннэмэх. Ойрхи цагийн товч. Ерөнхий редактор Л. Түдэв. Уб., 1996, х.5-20.

**Лувсанвандан С.** *Сономбалжирын Буяннэмэх*. Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. (1921-1965). Уб., 1968, х.175-208.

**Лувсанвандан С. С.** *Буяннэмэхийн уран бүтээл*. Монголын орчин үеийн уран зохиолын түүх. Тэргүүн дэвтэр. (1921-1940). Уб., 1988, х.177-206.

**Монгол ардын харилцаа дууны зүйлээс**. Эмхтгэсэн Э.Оюун. Уб., 1960.

**Мөнх Ц.** *Өмнөх үг*. Уран үгсийн чуулган 1929, 1969. Ред. Ц.Мөнх, Д.Пүрэвдорж. Уб., 1969, х.3-5.

**Мөнх Ц., Дуйнхаржав Г. С.** *Буяннэмэхийн амьдрал уран бүтээлийн товч* (1902-1937). С.Буяннэмэх. Түүвэр зохиол. Эмх. Г.Дуйнхаржав. Ред. Ц.Мөнх. Уб., 1968, х.5-10.

**Пүрэвдорж Д.** *Чандманийн түлхүүр*. Монголын уран зохиолын дээжис-70. Тоомойн Очирхүү. Урам хайрла. Ботгийн ред. Д.Пүрэвдорж. Шинэчилсэн хоёрдахь хэвлэл. Уб., 2006, х.5-8.

**Цэнд Д.** *Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл*. Уб., 1974.

**Цэрэнсодном Д.** *Монгол уран зохиол*. (XIII-XX зууны эхэн). Уб., 1987.